



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 сарын 08 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 7.19 дүгээр зүйл нэмсүгэй:

"7.19 дүгээр зүйл.Гэрийн тэжээвэр амьтны тухай хууль зөрчих

- 1.Гэрийн тэжээвэр амьтны асран хамгаалагч, түр харагчийн нохой, мууранд бичил чип суулгуулж, бүртгүүлэх, үржил хязгаарлах мэс ажилбар хийлгэхээс бусад үүргээ биелүүлээгүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- 2.Гэрийн тэжээвэр амьтны тухай хуульд заасан хугацаанд нохой, муур тус бүрд бичил чип суулгуулж, бүртгүүлээгүй бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- 3.Асран хамгаалагч нохой, мууранд үржил хязгаарлах мэс ажилбар хийлгэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- 4.Нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүйгээр нохой, муур үржүүлсэн бол хууль бус үйл ажиллагааг зогсоож, хууль бусаар олсон орлогыг хурааж, хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- 5.Эзэнгүй амьтныг түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүйгээр гэрийн тэжээвэр амьтныг түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхэлсэн бол хууль бус үйл ажиллагааг зогсоож, хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- 6.Нохой, муур худалдах, худалдан авах, шилжүүлэхэд тавигдах шаардлагыг зөрчсөн бол хууль бус үйл ажиллагааг зогсоож, хууль бусаар олсон орлогыг хурааж, хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- 7.Түр байрлуулан асрамжлах газар гэрийн тэжээвэр амьтныг худалдах, үржүүлэх үйл ажиллагаа эрхэлсэн бол хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- 8.Гэрийн тэжээвэр амьтныг үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх нийтлэг шаардлагыг удаа дараа зөрчсөн бол хуулийн этгээдийг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- 9.Эзэнгүй амьтныг түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх нийтлэг шаардлагыг удаа дараа зөрчсөн бол хуулийн этгээдийг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- 10.Гэрийн тэжээвэр амьтны эсрэг хүчирхийлэл үйлдсэн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- 11.Гэрийн тэжээвэр амьтны эсрэг хүчирхийллийг сурталчилсан, гэрийн тэжээвэр амьтны гаралтай түүхий эдийг ашиг олох зорилгоор боловсруулсан, худалдсан, худалдан авсан, гэрийн тэжээвэр амьтныг сугалаа, шагнал, урамшуулалд олгох, олгохоор амлах, сурталчилсан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гэрийн тэжээвэр амьтны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР